



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/533

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аргентин улсын Росарио хотод 2017 оны 10 дугаар сарын 02-08-ны хооронд болох өсвөр үе залуучуудын байт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаа төлөөлөн оролцох Э.Солонгод 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ